

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.09.18

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах, цаашид гарсан алдаа дутагдлыг давтахгүй ажиллах, удирдлагыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хяналт, шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ыг үндэслэв.

Гурав. Танилцуулга

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 07/1342 дугаартай албан бичгээр аудитын тайланг хүлээн авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт хуулийн хугацаанд Үндэсний Аудитын газарт тус тус хүргүүлсэн.

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын албан шаардлага, зөвлөмж, төлбөрийн актын хүрээнд 19 арга хэмжээнд хяналт хийж, хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар дүгнэлээ.

/Хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хавсралтаас харах/

Хүснэгт-1.

№	Шийдвэрийн төрөл	Тоо	100%	90%	70%	50%	0%	Чиг үүрэг шилжсэн	Нийт %
1	Төлбөрийн акт	1	1						100%
2	Албан шаардлага	10	3	1	3		2	1	66.7%
3	Зөвлөмж	8	5	1	1			1	94.3%
	Нийт арга хэмжээ	19	9	2	4		2	2	87.0%

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн нийт 19 арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж үзвэл албан шаардлагын хүрээнд 100%-3, 90%-1, 70%-3, 0%-2, чиг үүрэг шилсэн-1, зөвлөмжийн хүрээнд 100%-5, 90%-1, 70%-1, чиг үүрэг шилсэн-1, төлбөрийн актын хүрээнд 100%-1 арга хэмжээ, нийт төлөвлөгөөний хэрэгжилт 87.0 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэй байна

Үүнд: Төлбөрийн акт 1, албан шаардлага 10, зөвлөмж 8-ыг өгч тайландаа тусгаж ирүүлсэн. Энэ дагуу компанийн Санхүү, төлөвлөлтийн газар, Төсөл хөгжлийн газар, Захиргаа удирдлагын газруудаас нийт 19 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.